



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А131

Чойр

Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 242 дугаар тогтоол, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 272 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож олгохыг төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

2. Орон нутагт ажилласны нэмэгдэлд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт батлуулан санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Отгонтуяа/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/234 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ